

ХААН БАНК ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

АГУУЛГА

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	3
ХААН БАНК ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН.....	5
НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	5
ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ	7
ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ.....	9
ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО.....	10
ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА	11
ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ	13
ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ.....	14
НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ	16
ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ	17
НОТЛОХ БАРИМТЫН ЖАГСААЛТ.....	20

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс” болон Монголын Хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2022 оны А/58 дугаар тушаалын дагуу “Компанийн засаглалын кодексийг үнэлэх аргачлал”-ын дагуу ХААН Банк ХК (“Банк” гэх)-ийн засаглалын үнэлгээг танилцуулж байна.

2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээний үр дүнг Санхүүгийн зохицуулах хорооноос хянан баталгаажуулж 95.8 оноо буюу засаглал сайн, эрсдэлгүй гэж үнэлсэн.

1.1 Үнэлгээний зорилго

Энэхүү үнэлгээний зорилго нь “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад оршино.

Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-өөс томилогдсон эрх бүхий албан тушаалтан хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлнэ.

1.2 Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээ нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	СЗХ-ны хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	10	83.3
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	10	100
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	6	100
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	6	100
5	Эрсдэлийн удирдлага	8	8	8	100
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	5	83.3
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	8	100
8	Компанийн соёл	6	6	6	100
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	10	100
Нэгдсэн дүн		72	72	69	95.8

1.3 Үнэлгээний аргачлал

Асуулга тус бүрийн хүрээнд хийгдвэл зохих ажлын хэрэгжилтийг 0-2 оноогоор үнэлж, түүнийгээ хувьд шилжүүлэн, үнэлгээг 0-100 хувиар тооцож гаргасан болно. Үүнд:

- Бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2 оноо;
- Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилгоо тайлбарласан бол 1 оноо;
- Хэрэгжүүлээгүй, эсвэл үнэлгээ ирүүлээгүй бол 0 оноо.

Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

- Авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай гэж үзнэ.

1.4 Товчилсон үгийн жагсаалт

Товчлол

СЗХ
МХБ
КЗК
ТУЗ
ТУЗНБД
ТУЗАХ
ТУЗЭХ
ТУЗЗЦУХ
ТУЗНДХНХ
ГЗ
ХЭ
ХЭХ
ХЭЭХ
ХЭЭБХ
БОНЗ
ДА

Тайлбар

Санхүүгийн зохицуулах хороо
Монголын хөрөнгийн бирж
Компанийн засаглалын кодекс
Төлөөлөн удирдах зөвлөл
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
ТУЗ-ийн Аудитын хороо
ТУЗ-ийн Эрсдэлийн хороо
ТУЗ-ийн Засаглал, Цалин урамшууллын хороо
ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хороо
Гүйцэтгэх захирал
Хувьцаа эзэмшигч
Хувьцаа эзэмшигчдийн хурал
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал
Байгаль орчин, нийгэм, засаглал
Дотоод Аудит

**ХААН БАНК ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	1.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>ТУЗ-ийн дарга, ердийн болон хараат бус гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг хариуцлагыг Банкны дараах бодлого, журмаар нарийвчлан зохицуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн ХЭЭХ-ын 02 тоот тогтоолоор батлагдсан “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ын 3.1, 3.2, 6.1-6.5, 7.5, 7.6 заалтууд; ТУЗ-ийн 2024 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 03 тоот тогтоолоор батлагдсан “ТУЗ-ийн дэргэдэх ажлын албаны үйл ажиллагааны бодлого”-ын 3-р зүйл; 	2	100
2	1.2. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Банк нь ТУЗ-ийн гишүүдийн томилохдоо Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, журмуудад заасан шаардлага, шалгуурыг хангаж байгаа эсэх мэдээллийг Монголбанкинд хүргүүлж, зөвшөөрөл авсны үндсэн дээр томилдог. Банк ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг шийдвэрлэх ТУЗНДХНХ-той бөгөөд тус үйл ажиллагаанд дараах үндсэн бодлогын баримт бичгүүдийг чиглэл болгон ажилладаг.</p> <ul style="list-style-type: none"> Банкны Дүрмийн 9-р зүйл, 9.4 заалт; Банкны ТУЗ-ийн 2024 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 21 тоот тогтоолын хавсралтаар шинэчлэн батлагдсан ТУЗНДХНХ-ны Дүрэм; ХААН Банкны Хүний нөөцийн бодлого; ХААН Банкны Залгамж халаа бэлтгэх журам; <p>ТУЗ-ийн хараат бус гишүүдийн хувьд нэмэлтээр:</p> <ul style="list-style-type: none"> Монголбанкны “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”; 	2	100

			<ul style="list-style-type: none"> Банкны ТУЗ-ийн 2023 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 20 тоот тогтоолын Хавсралт 1-ээр батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”; 		
3	1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>2023 оны жилийн үйл ажиллагааны тайланд ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл, ТУЗ-ийн ажлын тайлан буюу ТУЗ-ийн болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлын тоо, хэлэлцсэн асуудал, тогтоол шийдвэр, гишүүдийн хуралдаанд оролцсон ирцийн мэдээллүүдийг тусгасан бөгөөд өөрийн болон Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсанд байршуулж ажилласан.</p> <p>Түүнчлэн ТУЗ-ийн 2023 оны ажлын тайланг 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн Банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсан.</p> <ul style="list-style-type: none"> ХААН Банкны 2023 оны жилийн үйл ажиллагааны тайлан; 	1	50
4	1.4. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага нь Банкны тухай хуулийн 31, 32, 33-р зүйлүүдээр зохицуулагдсан байдаг. ТУЗ болон түүний хороодын бүтэц бүрэлдэхүүн, хүйсийн тэнцвэрт байдал, ТУЗ-ийн гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлага болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргад тавигдах шаардлагыг Банкны дараах бодлогын баримт бичгүүдэд тусгасан байдаг.</p> <ul style="list-style-type: none"> Банкны Дүрмийн 9.1 заалт; ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 4, 8-р зүйл; Компанийн засаглалын кодекс; ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо, Аудитын хороо, Засаглал, цалин урамшууллын хороо болон Нэр дэвшүүлэх, хүний нөөцийн хорооны дүрмүүд; 	2	100
5	1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох,	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>ТУЗ-ийн гишүүнээр томилогдсон буюу сонгогдсоны дараа тус гишүүн нь Банкны стратеги, ерөнхий санхүү, эрх зүйн харилцаа, Банкны санхүүгийн тайлагналын тогтолцоо, Банк болон бизнесийн үйл ажиллагаанд тулгардаг онцгой асуудлууд болон ТУЗ-ийн гишүүний үүрэг, хариуцлага зэргийг хамруулсан чиглүүлэх сургалтад хамрагддаг. ТУЗ-ийн гишүүдийн сургалтын талаар Банкны дараах бодлогын баримт бичгүүдэд дэлгэрэнгүй тусгасан байдаг.</p> <ul style="list-style-type: none"> Компанийн засаглалын кодексийн 8-р зүйл; 	1	50

	шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.		<ul style="list-style-type: none"> • ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 17-р зүйл, • ТУЗНДХНХ-ны дүрмийн 3.1.5.2, 3.1.5.3, 3.2.4 заалтууд; <p>ТУЗ-ийн Ажлын алба нь ТУЗНДХНХ-той хамтран ТУЗ-ийн гишүүдэд ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг олох зорилгоор тогтмол сургалтыг зохион байгуулдаг бөгөөд энэ онд дараах сургалтуудыг явуулсан байна.</p> <ul style="list-style-type: none"> • 2024 оны 4-р сарын 23-нд Мэдээллийн аюулгүй байдлын сургалт; • 2024 оны 7-р сарын 25-нд БОНЗ-ийн гадны сургалт. 		
6	1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Банкны Дүрмийн 10.1 дэх хэсэгт “ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилно” гэж, 10.3 дахь хэсэгт “ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх, үүргийг түүнтэй байгуулах гэрээнд тусгана. ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай байгуулах гэрээний нөхцлийг ТУЗ баталгаажуулах ба ТУЗ-ийг төлөөлж, ТУЗ-ийн дарга гэрээнд гарын үсэг зурна” гэж тус тус тусгасан.</p> <p>Банкны ТУЗ нь жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн баталж, мөрдөн ажилладаг ба уг төлөвлөгөөний хэрэгжилттэй уялдуулан ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгдөг. Үнэлгээний тайланг ТУЗНДХНХ болон ТУЗ-ийн даргад тогтмол тайлагнан ажилладаг.</p> <p>Дээрх асуудлууд болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргын хүлээх эрх, үүргийн талаар дараах бодлогын баримт бичгүүдэд нарийвчлан зохицуулсан байдаг.</p> <ul style="list-style-type: none"> • Банкны Дүрэм 10-р зүйл; • Компанийн засаглалын кодекс 9-р зүйл; • ТУЗ-ийн үйл ажиллагааны журам 7-р зүйл; • ТУЗ-ийн дэргэдэх ажлын албаны үйл ажиллагааны бодлого 2-р зүйл, 4.1, 4.2 заалтууд; 	2	100
<p align="center">ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ</p> <p align="center">Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ</p>					
7	2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах	Бүрэн хэрэгжүүлсэн	Банкны Дүрэм, Компанийн Засаглалын Кодекс, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам (4.4 заалт)-д ТУЗ-ийн дарга нь хараат бус гишүүн байх ба болон ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн	2	100

	зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.		байхыг зорихоор тусгасан. 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн ТУЗ-ийн №28 тоот тогтоолоор ТУЗ-ийн даргаар хараат бус гишүүн Т.Дарьбумыг олонхын саналаар сонгосон. Мөн ТУЗ-ийн дэргэдэх хороодыг хараат бус гишүүд даргалж ажилладаг. Банкны бодлогын баримт бичгүүдэд энэ талаар тусгасан нь: <ul style="list-style-type: none"> • Банкны Дүрэм 9.1 болон 9.19 заалтууд; • Банкны ТУЗ-ийн үйл ажиллагааны журам 4.4 заалт; 		
8	2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам, аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗАХ-ны үйл ажиллагааг Банкны Дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, мөн тус хорооны дүрмээр зохицуулдаг. ТУЗАХ-ны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Тамир ажилладаг бөгөөд А.Тамир нь ТУЗ-ийн дарга бус болно. ТУЗАХ-ны хуралдаанд гүйцэтгэх удирдлага зөвхөн урилгаар оролцдог. <ul style="list-style-type: none"> • Банкны Дүрэм 11.3 заалт; • ТУЗ-ийн үйл ажиллагааны журам; • ТУЗАХ-ны дүрэм; 	2	100
9	2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗЗЦУХ-ны үйл ажиллагааг Банкны Дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, мөн тус хорооны дүрмээр зохицуулдаг. ТУЗЗЦУХ-ны даргаар хараат бус гишүүн А.Тамир ажилладаг бөгөөд А.Тамир нь ТУЗ-ийн дарга бус болно. ТУЗЗЦУХ-ны дүрмийг 2024 оны 6 сарын 24-ний өдөр шинэчлэн баталсан бөгөөд тус дүрмийн 3.1.2-т заасны дагуу ТУЗ-ийн удирдлагын бус гишүүд (үүнд ТУЗ-ийн хороодын гишүүд)-ийн цалин олговрын хүртээмжтэй байдлын талаар жилд нэгээс доошгүй удаа хяналт тавьж, ТУЗ-д санал зөвлөмж өгөх чиг үүрэгтэй ажилладаг. Банк нь цалин урамшууллыг Хүний Нөөцийн Бодлого, Банкны ажилтанд нэмэгдэл хөлс олгох журам зэрэг бодлогын баримт бичгүүдээр зохицуулдаг. Банкны Дүрмийн 7.2.13-т зааснаар ТУЗ-ийн цалин урамшууллын асуудлыг ТУЗ-ийн санал болгосоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар батладаг болно.	2	100

	удирдлага хорооны оролцоно.	гагцхүү хүсэлтээр	ТУЗЗЦУХ-ны хуралдаанд гүйцэтгэх удирдлага зөвхөн урилгаар оролцдог. <ul style="list-style-type: none"> • Банкны Дүрэм 11.5, 7.2.13; • ТУЗЗЦУХ-ны дүрэм; • ХААН Банкны Хүний нөөцийн бодлого; • ХААН Банкны Ажилтанд нэмэгдэл хөлс олгох журам; 		
10	2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗНДХНХ-ны үйл ажиллагааг Банкны Дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, мөн тус хорооны дүрмээр зохицуулдаг. ТУЗНДХНХ-ны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Х.Аарт ажилладаг бөгөөд Х.Аарт нь ТУЗ-ийн дарга бус болно. <ul style="list-style-type: none"> • Банкны Дүрэм 11.6; • ТУЗНДХНХ-ны дүрэм; • ХААН Банкны Хүний нөөцийн бодлого; • ХААН Банкны Залгамж халаа бэлтгэх журам; 	2	100
11	2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Банкны ТУЗ нь дэргэдээ дээр дурдсан хороодоос гадна ТУЗ-ийн Эрсдэлийн Хороо (ТУЗЭХ)-г байгуулж, ажиллуулдаг. ТУЗЭХ-ны даргаар ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн Т.Дарьбум ажилладаг. ТУЗЭХ-ийн хорооны үйл ажиллагааг Банкны Дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, тус хорооны дүрмээр зохицуулна. ТУЗ-ийн дэргэдэх хороод нь тус бүр үйл ажиллагааны дүрэм, журамтай бөгөөд ТУЗ-ийн гишүүд мэдлэг, ур чадвар, ажлын туршлагыг харгалзан хороодын бүрэлдэхүүнд орж ажилладаг. <ul style="list-style-type: none"> • Банкны Дүрэм 11.4; • ТУЗ-ийн үйл ажиллагааны журам; • ТУЗЭХ-ны дүрэм; 	2	100
ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ					
Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
12	3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал,	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ нь 2024 оны 09 сарын 20-ны өдрийн 27 тоот тогтоолоор “Мэдээллийн ил тод байдал, мэдээллийг толилуулах бодлого”-ыг шинэчлэн баталсан бөгөөд Банкны үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж	2	100

	тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.		байна. Тус бодлогын хэрэгжилтэд ТУЗ нь жилд нэгээс доошгүй удаа хяналт тавихаар зохицуулсан. <ul style="list-style-type: none"> ХААН Банк ХК-ийн Мэдээллийн ил тод байдал, мэдээллийг толилуулах бодлого; 		
13	3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Банкны засаглалын баримт бичиг, дүрэм, журам, Банкны үйл ажиллагаа, санхүүтэй холбоотой мэдээ мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан хөрөнгө оруулагч, олон нийтэд хүргэж, тогтмол шинэчлэн ажилладаг. 2024 оны 1-р улиралд Банкны цахим хуудасны Хөрөнгө оруулагчид цэсийг шинэчилж олон нийтэд хялбар болгож нэвтрүүлсэн. <ul style="list-style-type: none"> Банкны цахим хуудасны Хөрөнгө оруулагчид цэс 	2	100
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	ХААН Банк нь санхүүгийн тайлан, мэдээлэл, тодруулгуудыг холбогдох хууль, тогтоомж, тайлагналын олон улсын стандарт, зохицуулагч байгууллагын журам, зааварт нийцүүлэн бэлтгэн, санхүүгийн жилийн тайланг олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар баталгаажуулан тогтоосон цаг хугацаанд өөрийн цахим хуудасны Хөрөнгө оруулагчид цэсийн Тайлан, үзүүлэлт хэсэгт олон нийтэд нээлттэй тайлагнаж, тогтмол шинэчилдэг. Банк нь 2019 оноос жил бүр Тогтвортой хөгжлийн тайлангаа бэлтгэн олон нийтэд ил тод хүргэдэг болсон. Уг тайлан нь Банкны Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд Тогтвортой санхүүжилт, Тогтвортой үйл ажиллагаа, Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалт, Тогтвортой хамтын ажиллагаа ба тайлагнал гэсэн 4 чиглэлд хийж хэрэгжүүлсэн санал санаачлагууд, тоон мэдээлэл болон холбоотой баримт бичгүүдийн тухай мэдээллийг багтаадаг. Мөн тайланд Банкны Тогтвортой хөгжлийн бүтэц, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын зүгээс энэ чиглэлд тавьж буй зорилго зорилтын тухай мэдээллийг багтаадаг. Мөн Банкны үйл ажиллагааны тайлан, БОНЗ-ын тайланг Банк өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдэгддэг. <ul style="list-style-type: none"> Банкны цахим хуудасны Тогтвортой хөгжил цэс Банкны цахим хуудасны Тайлан, үзүүлэлт дэд цэс (МБ-ны журмын дагуу улирал бүр тайлагнадаг) 	2	100
ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО					
Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					
15	4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын	Бүрэн хэрэгжүүлсэн	Банкны ТУЗАХ-ны дүрмийн 2.1.3-т хөндлөнгийн аудитортой харьцах харилцааны талаар тусгасан байдаг. ТУЗАХ нь тус хорооны дүрмийн	2	100

	хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.		2.1.3-г заасны дагуу тус Банкны санхүүгийн тайланд хараат бус аудитыг хийх компанийг баталгаажуулж, хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцлөөр ханган ТУЗ-өөр батлуулдаг. <ul style="list-style-type: none"> • ТУЗАХ-ны дүрэм; • ТУЗ-ийн үйл ажиллагааны журам 2.1.4; 		
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Банкны ХЭЭХ-д жил бүр хөндлөнгийн аудитын байгууллагаас төлөөлөл биечлэн оролцож, тухайн жилийн аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулдаг. Хувьцаа эзэмшигчдэд хөндлөнгийн аудитороос асуулт асуух, мэдээлэл авах боломжоор хангагддаг. Түүнчлэн хөндлөнгийн аудитор нь ТУЗ-ийн хурал болон ТУЗАХ-ны хуралд оролцож, аудитын тайланг танилцуулдаг. <ul style="list-style-type: none"> • ХААН Банкны Дүрэм; • 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн ХЭЭХ-ын материал, хурлын тэмдэглэл; 	2	100
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	ДА-ын тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг Банкны жилийн үйл ажиллагааны тайланд зохих мэдээллийг тусгаж, цахим хуудсаар олон нийтэд мэдээлж ажилладаг. <ul style="list-style-type: none"> • Банкны 2023 оны жилийн тайлан; • Банкны цахим хуудасны Засаглалын Дотоод аудит хэсэг; • Банкны дотоод хяналтын бодлого; 	2	100
ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					
Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина.					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗЭХ нь Банкны Дүрэм болон тус хорооны дүрэмд заасан чиг үүргийн дагуу Банкны эрсдэлийн ерөнхий түвшинд нийцсэн эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, түүний	2	100

	эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.		хэрэгжилтэд хяналт тавих, Банкны эрсдэлийн удирдлагын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлон, үнэлэлт, дүгнэлт гаргах, ТУЗ-өөс тогтоосон хүлээн зөвшөөрөх эрсдэл болон эрсдэлийн лимитийн хэрэгжилтийг баталгаажуулах замаар ТУЗ-д Банкны эрсдэлийн түвшинг хянахад дэмжлэг үзүүлэн ажилладаг. ТУЗ нь Банкны эрсдэлийн хяналт, мониторингийн үйл ажиллагаатай холбоотой бодлого журмыг хянан баталдаг. <ul style="list-style-type: none"> • ХААН Банкны Дүрэм; • ТУЗ-ийн үйл ажиллагааны журам; • ТУЗЭХ-ны Дүрэм; • Банкны цахим хуудасны Засаглалын Эрсдэлийн удирдлага хэсэг; 		
19	5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Банкны Дүрмийн 11.1, 11.4-т заасны дагуу ТУЗ-ийн дэргэд Эрсдэлийн Хороо (ТУЗЭХ) ажилладаг ба тус хорооны даргаар ТУЗ-ийн дарга хараат бус гишүүн Т.Дарьбум 2024 оны 3 дугаар сараас эхлэн томилогдон ажиллаж байна. ТУЗ-ын үйл ажиллагааны журмын 8.5-д тус хорооны гишүүдийн олонх буюу гуравны хоёр (2/3) нь хараат бус гишүүн байхаар заасан ба энэ заалтыг бүрэн хэрэгжүүлсэн. ТУЗЭХ-ны үйл ажиллагаа, бүтэц бүрэлдэхүүний талаарх мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд тусган цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлдэг. Түүнчлэн хорооны ирц, хуралдсан асуудал, гаргасан шийдвэр, давтамжийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ХЭХ-д танилцуулж, ТУЗЭХ-ны хараат бус гишүүдийн ажлын тайланд тусгасан байдлаар улирал бүр зохицуулагч байгууллагад, хагас жил бүр банкны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж байна. <ul style="list-style-type: none"> • Банкны Дүрэм; • ТУЗ-ийн үйл ажиллагааны журам; • ТУЗЭХ-ны дүрэм; • ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тайлан; • Банкны 2023 оны жилийн тайлан; 	2	100
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн	Бүрэн хэрэгжүүлсэн	Банк нь 2019 оноос жил бүр Тогтвортой хөгжлийн тайлангаа бэлтгэн олон нийтэд ил тод хүргэдэг болсон.	2	100

	хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.		2022 оноос БОНЗ-ын тайланг БОНЗ-ын тайлангийн маягтын дагуу үнэлгээ хийн тайлан бэлтгэж МХБ болон өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж эхэлсэн. Түүнчлэн жилийн тайланд Тогтвортой хөгжил бүлгийг оруулж тогтвортой хөгжил болон байгаль орчин, нийгэм, засаглалын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тусгаж олон нийтэд тайлагнадаг.		
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	Банкны Комплаенсийн газар нь Банкны үйл ажиллагааны комплаенсийн хяналтыг бүрэн хариуцаж мөн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа ТУЗ-д болон ТУЗЭХ-д сар бүр тайлагнадаг. Банк нь үйл ажиллагаандаа комплаенсийн хяналттай холбоотой дараах бодлогын баримт бичгүүдийг мөрдөж ажилладаг. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Комплаенсийн бодлого; • Компленсийн газрын дотоод үйл ажиллагааны журам; • Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам; 	2	100
ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна.					
22	6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн гишүүдийн цалин олговрын хүртээмжтэй байдлын талаар ТУЗЗЦУХ жилд нэгээс доошгүй удаа хяналт тавьж, ХЭХ-д санал зөвлөмж өгөх чиг үүрэгтэй ажилладаг. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын зардлын төсвийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар ил тод хэлэлцэж батладаг. 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр болсон ХЭЭХ-аар 2024 оны ТУЗ-ийн зардлын төсвийг хэлэлцэж баталсан. Түүнчлэн 2023 оны жилийн үйл ажиллагааны тайланд ТУЗ-ийн гишүүдийн цалингийн төсвийг тайлагнаж МХБ болон өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн. <ul style="list-style-type: none"> • Банкны 2023 оны үйл ажиллагааны жилийн тайлан (ҮЦБЖ-ын хавсралт маягтын дагуу); • 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн ХЭЭХ-ийн 03 тогтоол; 	2	100
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл	Бүрэн хэрэгжүүлсэн	Банк нь цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт бүрэн тусган, мөрдөж ажилладаг.	2	100

	хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.		<ul style="list-style-type: none"> • ХААН Банк ХК-ийн Хүний Нөөцийн Бодлого, 4-р Бүлэг; • ХААН Банк ХК-ийн Ажилтны гүйцэтгэлийн удирдлагын тухай журам; 		
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Банкны жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгасан.</p> <p>ТУЗНДХНХ нь гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийн мэдээллийг улирал тутам авч, хяналт тавьдаг. Жил бүр санхүүгийн аудитлагдсан тайлан гарсны дараа ГЗ жилийн ажлын гүйцэтгэлийг ТУЗ хэлэлцэн баталж, үндсэн цалингийн хэмжээ болон урамшууллын хэмжээг тогтоодог.</p> <ul style="list-style-type: none"> • Банкны Хүний нөөцийн бодлого 4-р зүйл; • Банкны 2023 оны үйл ажиллагааны жилийн тайлан (ҮЦБЖ-ын хавсралт маягтын дагуу); 	1	50
ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Банк нь өөрийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлсээр ирсэн. Энэ талаар Компанийн засаглалын кодекс-ийн 4-р хэсэг: Оролцогч талуудын эрх ашиг-т тусгаж өгсөн.</p> <p>Банкны Ёс зүйн дүрмийг ТУЗХНХ 2023 онд шинэчлэн баталсан бөгөөд тус Дүрмийн 1.2-т заасны дагуу харилцагч, ажлын түнш, хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд, банкны ажилтнуудын ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээрийн хоорондын харилцааны үндсийг тодорхойлохыг дүрмийн зорилт болгосон байна.</p> <p>Энэ хүрээнд мөн Банкны ТУЗ-өөс 2024 оны 1 дүгээр сард “Хөрөнгө оруулагчидтай харилцах бодлого”-ыг баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус бодлого нь хөрөнгө оруулагчид болон боломжит хөрөнгө оруулагчдыг хөрөнгө оруулалтын тухай шийдвэр гаргахад мэдээллээр хангах, бусад оролцогчдод Банк, түүний зорилгын талаар тэнцвэртэй ойлголтыг хүргэхэд Банкныг шударга, үнэн зөвөөр төлөөлөх зорилготой юм.</p> <ul style="list-style-type: none"> • ХААН Банк ХК-ийн Ёс зүйн дүрэм; • ХААН Банк ХК-ийн Компанийн засаглалын кодекс; 	2	100

			<ul style="list-style-type: none"> ХААН Банк ХК-ийн Хөрөнгө оруулагчидтай харилцах бодлого; 		
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Банкны жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтын ажиллагааны талаарх мэдээллийг тусгадаг бөгөөд хувьцаа эзэмшигч, олон нийтэд хэрэгцээт мэдээ мэдээллийг хүргэж мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилладаг.</p> <p>2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланд Тогтвортой Бизнес стратегийн хүрээнд харилцагчийн туршлагыг сайжруулах, эрсдэлийг удирдах замаар бизнесийн өсөлтийг хангах, цахим банкны үйлчилгээг сайжруулах, байгууллагын хөгжлийг дэмжих чиглэлээр голлон хийгдсэн ажлуудыг дурдав.</p> <ul style="list-style-type: none"> Банкны 2024 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан – МХБ-ийн www.mse.mn цахим хуудас дээр тайлагнасан. Банкны 2024 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан – Банкны www.khanbank.com цахим хуудас дээр тайлагнасан. 	2	100
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Оролцогч талуудад зориулсан шаардлагатай мэдээллийг Банкны цахим хуудас болон МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан хүргэж, тогтмол шинэчлэн ажилладаг.</p> <p>2024 оны 1-р улиралд банкны цахим хуудас дахь “Хөрөнгө оруулагчид” цэсийг шинэчилж, хөрөнгө оруулагчид болон олон нийтэд шаардлагатай мэдээллийг нэг дор төвлөрүүлэн, ашиглахад хялбар болгосон. Бид энэ цэс болон МХБ-ийн цахим хуудас дээр холбогдох мэдээллийг цаг тухай бүрт оруулж, тогтмол шинэчлэн ажилладаг.</p> <ul style="list-style-type: none"> Банкны цахим хуудасны Хөрөнгө оруулагчид цэс; МХБ-ийн цахим хуудас дахь ХААН Банк цэс; 	2	100
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Банкны Ажилтны гомдол шийдвэрлэх үйл ажиллагааны журмыг ГЗ-ын 2023 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 01/194 тоот тушаалаар батласан. Банкны ТУЗ-ийн 2024 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн тогтоолоор “Шүгэл үлээх бодлого”-ыг шинэчлэн баталж мөрдөн ажиллаж байна. Түүнчлэн Банкны цахим хуудас дахь “Шүгэл үлээх” цэсийг шинээр нэвтрүүлсэн.</p> <p>Ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалттай холбоотой үйл ажиллагааг ХААН Банк Академи эрхлэн хариуцдаг. Ажилтны нийгмийн асуудал дээр Хөдөлмөрийн дотоод журмын 6, 7-р</p>	2	100

			<p>бүлгүүдэд амралт чөлөө, уян хатан ажиллуулах журам, шагнал урамшуулал, нийгмийн хангамжийн талаар тусгаж өгсөн байна. Ажилтнуудын нийгмийн хөгжилд зориулж нийгмийн хөгжлийн тусгай санхүүжилт олгодог бөгөөд энэ нь Хөдөлмөрийн дотоод журамд тусгагдсан. Мөн Банкны ажилтнуудын хөдөлмөрийн харилцааны ERP цахим систем дээр санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэхтэй холбоотой харилцааг тусгаж өгсөн байдаг.</p> <ul style="list-style-type: none"> • ХААН Банк ХК-ийн Шүгэл үлээх бодлого; • Банкны цахим хуудасны Шүгэл үлээх цэс; • ХААН Банк ХК-ийн Хүний Нөөцийн Бодлого; • ХААН Банк ХК-ийн Ажилтны гомдол шийдвэрлэх үйл ажиллагааны журам; • ХААН Банк ХК-ийн Сургалт хөгжлийн үйл ажиллагааны журам; 		
НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ					
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Банкны ТУЗ 2015 оны 5 дугаар сарын 26-ны өдөр 12 тоот тогтоолоор анхлан батлагдсан “Ёс зүйн дүрэм”-д үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах талаар нарийвчлан заасан байдаг. Мөн Ёс зүйн дүрэмд ТУЗНДХНХ жил бүр хяналт тавин ажилладаг.</p> <ul style="list-style-type: none"> • ХААН Банк ХК-ийн Ёс зүйн дүрэм; 	2	100
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Банкны ТУЗ-ийн 2024 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 09 тоот тогтоолоор “Шүгэл үлээх бодлого”-ыг шинэчлэн баталж, мөрдөн ажиллаж байна. Мөн Банкны цахим хуудас дээр “Шүгэл үлээх” цэсийг нэвтрүүлсэн. Шүгэл үлээх бодлогод шүгэл үлээх асуудлыг хэрхэн дэвшүүлэх, хянан шалгах, шаардлагатай тохиолдолд арга хэмжээ авах талаар үүргийг тодорхой зааж өгсөн. Шалгагч нь мэдээллийг хүлээн авч шийдвэрлэхдээ шүгэл үлээгчийн нууцлалыг</p>	2	100

	үлээгчийн” тогтолцоотой байна.		хадгалж, ажил хэргийн нэр хүнд, цалин урамшуулал, ажлын байрыг нь Монгол Улсын Иргэний хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм журамд нийцүүлэн хамгаална. Тус асуудлаар шийдвэрлэсэн мэдээллийн талаар ТУЗ-ийн Аудитын хороонд хагас жил тутам тайлан болон мэдээлэл хүргүүлж ажилладаг. <ul style="list-style-type: none"> • ХААН Банк ХК-ийн Шүгэл үлээх бодлого; • Банкны цахим хуудасны Шүгэл үлээх цэс; 		
31	8.3. Ёс зүйн дүрмээр авилга, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Банкны Ёс зүйн дүрэм болон бусад дотоод баримт бичгүүдэд авилга, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулалтуудыг тусгаж, холбогдох дотоод нэгжүүд хяналтыг хэрэгжүүлдэг. <ul style="list-style-type: none"> • ХААН Банк ХК-ийн Ёс зүйн дүрэм; • Авилга, хээл хахуулийн эсрэг бодлого; • Улс төрд нөлөө бүхий этгээдийн бодлого; 	2	100
ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Банк нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, олон нийтэд хүргэх өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх хугацаат болон тухай бүр мэдээлэх мэдээллийг өөрийн болон МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан нээлттэй байдлаар хугацаанд толилууль, тогтмол шинэчлэн ажилладаг. <ul style="list-style-type: none"> • Банкны цахим хуудасны Хөрөнгө оруулагчид цэс; • МХБ-ийн цахим хуудас дээрх ХААН Банк ХК хэсэг (https://mse.mn/mn/company/563); 	2	100
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл	Бүрэн хэрэгжүүлсэн	Банкны ТУЗ-ийн 2024 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр 03 тоот тогтоолоор “Хөрөнгө оруулагчидтай харилцах бодлого”-ыг баталсан. Энэхүү бодлого нь хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид болон олон нийтэд үнэн зөв, бодит мэдээллийг тодорхой, шударга, тэнцвэртэй хүргэх нөхцлийг хангах зорилготой. Тус бодлогын	2	100

	солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.		хүрээнд Банк нь хөрөнгө оруулагчидтай албан ёсны цахим шуудан (investor_relations@khanbank.com) ашиглан шууд харьцдаг. Мөн цахим хуудасдаа “Хөрөнгө оруулагчид” цэсийг шинэчлэн нэвтрүүлсэн бөгөөд энэ цэсээр оролцогч талуудад банкны талаархи мэдээллийг тогтмол хүргэж, санал хүсэлтийг нээлттэй хүлээн авч, хариу өгөх үйл ажиллагааг явуулж байна. <ul style="list-style-type: none"> • Банкны цахим хуудасны Хөрөнгө оруулагчид цэс; • Хөрөнгө оруулагчидтай харилцах бодлого; 		
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүнд санал өгөх эрх, ногдол ашиг авах эрх болон бусад эрхүүдийг Компанийн тухай хууль, Банкны тухай хуульд заасны дагуу баталгаажуулж Банкны Дүрмийн 6-р зүйл болон Компанийн засаглалын кодекст тодорхой зааж өгсөн. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож саналаа өгөх боломжгүй хувьцаа эзэмшигчдэд зориулж хосолсон хэлбэрээр (цахим) хурал зохион байгуулах мөн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан саналаа өгөх боломжийг олгодог. Түүнчлэн гадаад хувьцаа эзэмшигч нарт хурлын материал, саналын хуудас, цахим хуудас зэргийг гадаад хэл дээр бэлтгэн хүргүүлдэг. <ul style="list-style-type: none"> • ХААН Банк ХК-ийн Дүрэм; • Компанийн засаглалын кодекс; • Банкны цахим хуудасны Хувьцаа эзэмшигчдийн хурал дэд цэс; 	2	100
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Банкны Дүрмийн 6-р зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн эрх, үүргийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, зохицуулагч байгууллагуудын журам, дүрэмд нийцүүлэн тодорхой заасан ба үүн дотор Банкны үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ эдлэх нөхцлийг хангаж өгсөн. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц болон шийдвэр гаргалтыг холбогдох хуулийн босго хувиас өндөр буюу хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонх (66.67%-иас доошгүй хувь)-ийг хангуулахаар зохицуулсан. Хувьцаа Банкны хувьцаа эзэмшигчид нь Хувьцаа эзэмшигчдийн хуралд цахимаар болон биечлэн оролцох, өөрийн биеэр болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан санал өгөх эрхтэй бөгөөд эдгээр эрх, үүргийг танилцуулах гарын авлагыг Банкны цахим хуудсанд байршуулсан.	2	100

			<ul style="list-style-type: none"> • ХААН Банк ХК-ийн Дүрэм; • Хувьцаа эзэмшигчдийн гарын авлага; 		
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Банкны ТУЗ-ийн 2024 оны 2 дугаар сарын 15-ны өдөр 05 тоот тогтоолоор “Ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл болон Их хэмжээний хэлцэл хийх бодлого”-ыг шинэчлэн баталсан бөгөөд 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр 28 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан. Банк нь Монголбанканд сар бүр санхүүгийн тайлан, холбогдох этгээдэд хийсэн хэлцлийн мэдээллийг тайлагнаж, энэ талаарх мэдээ, тайланг цахим хуудсандаа тогтмол байршуулдаг. Мөн сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн тухай мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тухай бүр МХБ болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд шуурхай мэдээлдэг.</p> <ul style="list-style-type: none"> • Ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл болон Их хэмжээний хэлцэл хийх бодлого; • Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлүүд; • Нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалт; 	2	100

НОТЛОХ БАРИМТЫН ЖАГСААЛТ

1. ХААН Банк ХК-ийн Дүрэм
2. ХААН Банк ХК-ийн Ёс зүйн дүрэм
3. ХААН Банк ХК-ийн Компанийн засаглалын кодекс
4. ХААН Банк ХК-ийн Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр
5. ХААН Банк ХК-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
6. ХААН Банк ХК-ийн ТУЗ-ийн Аудитын хорооны дүрэм
7. ХААН Банк ХК-ийн ТУЗ-ийн Эрсдэлийн хорооны дүрэм
8. ХААН Банк ХК-ийн ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хорооны дүрэм
9. ХААН Банк ХК-ийн ТУЗ-ийн Засаглал, Цалин урамшууллын хорооны дүрэм
10. ХААН Банк ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх ажлын албаны үйл ажиллагааны бодлого
11. ХААН Банк ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах журам
12. ХААН Банк ХК-ийн Хөрөнгө оруулагчидтай харилцах бодлого
13. ХААН Банк ХК-ийн Ногдол ашгийн бодлого
14. ХААН Банк ХК-ийн Мэдээллийн ил тод байдал, мэдээллийг толилуулах бодлого
15. ХААН Банк ХК-ийн Ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл болон Их хэмжээний хэлцэл хийх бодлого
16. ХААН Банк ХК-ийн Хүний нөөцийн бодлого
17. ХААН Банк ХК-ийн Залгамж халаа бэлтгэх журам
18. ХААН Банк ХК-ийн Ажилтанд нэмэлт хөлс олгох журам
19. ХААН Банк ХК-ийн Ажилтны гүйцэтгэлийн удирдлагын тухай журам
20. ХААН Банк ХК-ийн Ажилтны гомдол шийдвэрлэх үйл ажиллагааны журам
21. ХААН Банк ХК-ийн Сургалт хөгжлийн үйл ажиллагааны журам
22. ХААН Банк ХК-ийн Шүгэл үлээх бодлого
23. ХААН Банк ХК-ийн Дотоод хяналтын бодлого
24. ХААН Банк ХК-ийн Комплаенсийн бодлого
25. ХААН Банк ХК-ийн Комплаенсийн газрын дотоод үйл ажиллагааны журам
26. ХААН Банк ХК-ийн Мөнгө угаах терроризмийг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам
27. ХААН Банк ХК-ийн Авлига, хээл хахуулын эсрэг бодлого
28. ХААН Банк ХК-ийн Улс төрд нөлөө бүхий этгээдийн бодлого
29. ХААН Банк ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны тайлан
30. ХААН Банк ХК-ийн 2024 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан
31. ХААН Банк ХК-ийн 2023 оны Тогтвортой хөгжил, БОНЗ-ын тайлан
32. ХААН Банк ХК-ийн 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоол, хурлын тэмдэглэл
33. ХААН Банк ХК-ийн цахим хуудас – Хөрөнгө оруулагчид цэс
34. ХААН Банк ХК-ийн цахим хуудас – Шүгэл үлээх цэс
35. Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас – ХААН Банк ХК цэс